



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

Хорт хавдрын тусламж, үйлчилгээний
чанар, хүртээмжийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёрдах хөтөлбөр”, “Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр”, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх, хорт хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг 2015 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга, захирал, ерөнхий эмч нарт үүрэг болгосугай.

3. Хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх, хорт хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар авах арга хэмжээний удирдамжийн хэрэгжилтийг мэргэжил арга зүй, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төв (Л.Төмөрбаатар)-д даалгасугай.

4. Энэхүү удирдамжийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т даалгасугай.


5. Арга хэмжээнд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Стратеги, төлөвлөлтийн газрын дарга (Р.Оюунханд), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 292 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

031242

7.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09 сарын 10 өдрийн
3.5.1 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

Хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх, хорт хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж

Зорилго: Аймаг, дүүргийн түвшинд хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Нэг. Урьдчилан сэргийлэлтийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

- 1.1 Хепатитийн Б вирусийн дархлаажуулалтын хамралтыг сайжруулах, эрсдэлт бүлгийн хүн амыг сайн дурын дархлаажуулалтад хамруулах ажил зохион байгуулах,
- 1.2 Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлс (архи, тамхины хэрэглээ, зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, таргалалт, орчны болон ажлын байрны хүчин зүйлс гэх мэт)-ийн тархалтыг бууруулахад чиглэсэн өөрийн аймаг, дүүргийн хэрэгцээнд нийцсэн ажил төлөвлөн хэрэгжүүлэх,
- 1.3 Хавдрын эрсдэлт хүчин зүйлс, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд иргэд, хувь хүн, хамт олон, төр, төрийн бус, олон улсын байгууллагын болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх,
- 1.4 Орчны болон мэргэжлийн хортой нөлөөлөл, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт түүний ач холбогдолын талаар аж ахуйн нэгж, байгууллагын хамт олон, иргэд, олон нийтэд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах,
- 1.5 Байгууллагуудад халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг хянаж бууруулахад дэмжлэг болох орчин (чийрэгжүүлэлтийн заал тохижуулах, архи, тамхины хор хөнөөлийн талаар мэдээлэл, сургалт хийх, ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах гэх мэт) бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах,
- 1.6 Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдлын талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах,
- 1.7 Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт зориулсан ухуулга, сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулах.

Хоёр. Эрт илрүүлэлтийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар

2.1 Хөх умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хөтөлбөрийн чиглэлээ

- 2.1.1 Хөх, умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт шаардлагатай эм, урвалжийн тооцоог жил бүр хийж, орон нутгийн төсөвт тусгуулах,

- 2.1.2 Эрт илрүүлэг үзлэгийг тасралтгүй, хүртээмжтэй зохион байгуулах хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх, эмч, мэргэжилтнүүдийг сургах,
- 2.1.3 Эрт илрүүлэг үзлэгийн бүртгэл мэдээллийн Эргэн дуудах тогтолцооны хэрэгжилтийг сайжруулах,
- 2.1.4 Эрт илрүүлэг үзлэгийн хамралтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх.

2.2 Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх стратегийн хэрэгжилтийн чиглэлээр

- 2.2.1. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн хэт авиан оношлогооны кабинетийг шинээр зохион байгуулах,
- 2.2.2. Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж, урвалж бодис, дижитал ЭХО аппаратын хэрэгцээ шаардлагыг тогтоож, хангах,
- 2.2.3. Лабораторийн урвалж бодисоор тасралтгүй хангах зардлын тооцоог жил бүр хийж, санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгуулан шийдвэрлэх,
- 2.2.4. Элэгний хорт хавдрын илрүүлэг үзлэгт хамрагдах, эрт үеийн шинж тэмдгийг мэдэж эмчид хандах талаар хүн амд мэдлэг олгох сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах,
- 2.2.5. Элэгний хорт хавдар эрт илрүүлэх стратегийн хэрэгжилтэд орон нутгийн түвшинд хяналт үнэлгээ хийх

Гурав.Оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар

3.1 Оношилгооны чадавхийг аймаг, дүүргийн түвшинд сайжруулах чиглэлээр

- 3.1.1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хавдрын хими, хөнгөвчлөх эмчилгээ, хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлэх 15-аас доошгүй ортой хавдрын тасаг байгуулах,
- 3.1.2. Хавдрын тасаг байгуулах, стандартын түвшинд ажиллуулахад шаардлагатай зардлыг тооцож, орон нутгийн төсөвт тусгах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- 3.1.3. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эс, эдзүйн шинжилгээний чадавхийг бэхжүүлэх,
- 3.1.4. Сум, өрхийн эрүүл мэндийн төв (анхан шатны тусламж үйлчилгээ)-ийн түвшинд хавдрын урьдал өвчнийг илрүүлэх, шилжүүлэх, хянах, хөнгөвчлөх эмчилгээний чадамжийг дээшлүүлэх,
- 3.1.5. Өөрийн аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын оношилгооны чадамжид хэрэгцээний судалгаа хийж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.

3.2 Хорт хавдрын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр

- 3.2.1. *Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад хими эмчилгээ хийх аюулгүй ажиллагааны нөхцлийг хангасан ламинар бокстой байх,*
- 3.2.2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хими эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, өдрийн эмчилгээг өргөтгөх,
- 3.2.3. Хими эмчилгээний эмээр тасралтгүй хангах,
- 3.2.4. Хавдрын дэмжих үйлчилгээ болох сэтгэл засал, хоол эмчилгээ, нийгмийн тусламж үйлчилгээ болон нөхөн сэргээх эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

3.3 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр

- 3.3.1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийг хөнгөвчлөх тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх чадвартай болгох,

- 3.3.2. Өвдөлт намдаах эмчилгээг ДЭМБ-ын удирдамжийн дагуу хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай эмээр тасралтгүй хангах,
- 3.3.3. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийг хөнгөвчлөх эмчилгээний шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах,
- 3.3.4. Гэр бүл, асран хамгаалагч нарыг хөнгөвчлөх асаргаа, сувилгааг гэрээр үзүүлэх чадварт сургах,
- 3.3.5. Өвдөлт намдаах эмчилгээний арга зүйд сум, өрхийн эмч нарыг сургах.

Дөрөв. Хорт хавдрын бүртгэл, тандалтыг сайжруулах талаар

- 4.1. Аймаг, дүүргийн Иргэний бүртгэл, мэдээллийн үндэсний төвтэй газартай хамтран ажиллаж, хорт хавдрын бүртгэлийг сайжруулах,
- 4.2. Аймаг, дүүргийн Иргэний бүртгэлийн газрын хүн амын мэдээний сантай тулгалтыг жилд 2 удаа хийж, өвчлөл, нас баралтын мэдээний чанарыг сайжруулах,
- 4.3. Харьяа нутаг дэвсгэрийн хорт хавдраар өвчлөгсдийн хяналтын мэдээний санг Хорт хавдрын үндэсний бүртгэлийн мэдээний сантай жилд 2 удаа тулгалт хийж, мэдээллээ баталгаажуулах,
- 4.4. Хорт хавдрын бүртгэлийн програм хангамжийн дагуу өвчлөл, нас баралтын мэдээний сан бүрдүүлэх,
- 4.5. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний талаар тайлан, мэдээ, бүртгэлийн маягтыг боловсронгуй болгох, мэдээний сан бий болгох,
- 4.6. Өөрийн аймаг, дүүргийн хэрэгцээ шааадлагад нийцсэн хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх, тусламж, үйлчилгээг төлөвлөх, бодлого боловсруулахад чанартай мэдээллээр хангах.

Тав. Хүний нөөцийг бэхжүүлэх талаар

- 5.1. Хавдар судлаач эмч, сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний эмч, сувилагч, хавдар бүртгэгчийг орон тоогоор ажиллуулах,
- 5.2. *Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажиллах хавдрын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийг тасралтгүй давтан сургах сургалтыг зохион байгуулах,*
- 5.3. Өрх, сумын эмч, сувилагч нарыг хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр тасралтгүй сургах ажлыг зохион байгуулах,
- 5.4. Сэтгэл зүй, нөхөн сэргээх, хоол зүй зэрэг дэмжих тусламж үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийг сургах,
- 5.5. Эмч, мэргэжилтний сургалтад телемедициныг өргөн ашиглах,
- 5.6. Эмч, мэргэжилтний зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулж, эмч, мэргэжилтнүүдийг хамруулах.

Зургаа. Хавдар судлалын үндэсний төвийн чиг үүрэг

- 6.1. Хавдар судлалын үндэсний төв нь хорт хавдраас сэргийлэх, хянах ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүй, зохицуулалтаар хангаж ажиллах,
- 6.2. Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний удирдамж боловсруулж, мэргэжлийн удирдлагаар хангах,
- 6.3. Шинээр нэвтэрсэн оношилгоо, эмчилгээний арга, технологид эмч, мэргэжилтнүүдийг сургах, дадлагажуулах,
- 6.4. Хорт хавдартай өвчтөнг эрүүл мэндийн байгууллага хооронд шилжүүлэх журам боловсруулах,
- 6.5. Хорт хавдрын өвчлөл, нас баралтын болон зарим шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах,

- 6.6. Үндэсний телемедициний сүлжээг ашиглан хөнгөвчлөх эмчилгээ, сэтгэлзүйн болон бусад дэмжих тусламж үйлчилгээний чиглэлээр аймаг, дүүргийн, өрх, сумын эмч, мэргэжилтнүүдийг сургах ажлыг зохион байгуулах,
- 6.7. Хавдрын бүртгэгч, өрх, сумын эмч, мэргэжилтнүүдийг хорт хавдрын идэвхитэй тандалт хийх мэргэжлийн арга зүйгээр хангах,
- 6.8. Хөнгөвчөх тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэх болон өдрийн хими эмчилгээ хийх аргачилсан зааварчилгаагаар хангах.

